

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гадаадын иргэн, харьяатын Баруун бүс дэх газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/27/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Улаанбаатар хот

2022 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Балжинням

Утас: 70432545

цахим хаяг: baljinnyam.d@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	3
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
3. Аудитын тайлан.....	8
3.1 Ерөнхий зүйл.....	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	11
3.8 Аудитын гол асуудал	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	11
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	11
4. Аудитын илрүүлэлт	12
4.1 Залруулсан алдаа.....	12
4.2 Төлбөрийн акт.....	12
4.3 Зөвлөмж	12
5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
НА	Нотлох ажил
ГИБГББДГ	Гадаадын иргэн харьяатын газрын баруун бүс дэх газар

1.Аудитын санал дүгнэлт



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2022.02.09 № 2/7
танай _____ -ны № _____ -т

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН
ГАЗРЫН БАРУУН БҮС ДЭХ ГАЗРЫН
ДАРГА А.ХУАНБАЙ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гадаадын иргэн, харьяатын газрын Баруун бүс дэх газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гадаадын иргэн, харьяатын газрын Баруун бүс дэх газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хөрөглөгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

021020257

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>69471716.33</u>	<u>67610522.70</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	69471716.33	67610522.70
351	Түүхий эд материал	0.00	694377.00
35130	Эм боох материал	0.00	694377.00
354	Хангамжийн материал	69471716.33	66916145.70
35410	Бичиг хэргийн материал	5095050.00	5252260.00
35420	Аж ахуйн материал	13554046.56	10924081.58
35440	Түлш, шатах тослох материал	8121388.50	2057584.12
35450	Барилгын засварын материал	405000.00	405000.00
35470	Бусад хангамжийн материал	42296231.27	48277220.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>247253304.33</u>	<u>225603194.55</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	247253304.33	225603194.55
392	Биет хөрөнгө	234263304.33	213108194.55
39201	Барилга, байгууламж, орон сууц	106129723.99	106129723.99
39202	Хуримтлагдсан элэгдэл	-15837471.86	-19740714.86
39203	Авто-тээврийн хэрэгсэл	220394082.75	229144082.75
39204	Хуримтлагдсан элэгдэл	-153524637.94	-162187138.08
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	345645526.96	139844469.96
39206	Хуримтлагдсан элэгдэл	-279992182.22	-87552662.38
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	39565176.34	27876914.54
39208	Хуримтлагдсан элэгдэл	-28116913.69	-20406481.37
393	Биет бус хөрөнгө	12990000.00	12495000.00
39301	Програм хангамж	1980000.00	1980000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-990000.00	-1485000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	12000000.00	12000000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>316725020.66</u>	<u>293213717.25</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>316725020.66</u>	<u>293213717.25</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	316725020.66	293213717.25
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	12000000.00	12000000.00
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	12000000.00	12000000.00
512	Хуримтлагдсан үр дүн	301886539.46	278375236.05
51210	Өмнөх үеийн үр дүн	301886539.46	301886539.46
51220	Тайлант үеийн үр дүн		-23511303.41
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2838481.20	2838481.20
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>316725020.66</u>	<u>293213717.25</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	<u>784776959.03</u>	<u>696344301.78</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<u>49841259.03</u>	<u>99071701.78</u>

120	Нийтлэг татварын бус орлого	49841259.03	99071701.78
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	49841259.03	99071701.78
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	49841259.03	99071701.78
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	734935700.00	597272600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	734935700.00	597272600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	734935700.00	597272600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	876693636.30	667670946.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	876693636.30	667670946.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	749781233.54	625445629.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	466110108.61	444179623.20
210101	Үндсэн цалин	303207489.02	275632646.38
210102	Нэмэгдэл	72567810.56	103571858.11
210103	Унаа хоолны хөнгөлөлт	50348889.18	58320006.71
210104	Урамшуулал	39985919.85	6655112.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56380840.17	58052864.39
210201	Тэтгэврийн даатгал	33694040.17	40020416.33
210202	Тэтгэмжийн даатгал	5673600.00	4508087.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4540400.00	3606469.43
210204	Ажилгүйдлийн даатгал	1133200.00	901617.55
210205	Эрүүл мэндийн даатгал	11339600.00	9016274.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21465278.67	15912785.28
210301	Гэрэл, цахилгаан	6894718.67	5776622.31
210302	Түлш, халаалт	7714060.00	3606662.97
210303	Цэвэр, бохир ус	709500.00	379500.00
210304	Байрны түрээс	6147000.00	6150000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	81995292.13	22733313.62
210401	Бичиг хэрэг	3645650.00	2774390.00
210402	Тээвэр, шатахуун	16424502.20	15463804.38
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1539869.00	1271419.24
210404	Ном, хэвлэл	484500.00	92000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6959485.00	3131700.00
2105	Нормативт зардал	1010200.00	6223095.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1010200.00	6223095.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5252400.00	6539738.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	715000.00	3515038.00
210604	Урсгал засвар	4537400.00	3024700.00
2107	Томилолт, зочны зардал	4894200.00	1996000.00
210702	Дотоод албан томилолт	4894200.00	1996000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3894083.00	8437531.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		45000.00
210803	Даатгалын үйлчилгээ	420000.00	356700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	443520.00	552031.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	135600.00	111300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1302000.00	1049000.00

210807	Газрын төлбөр	81430.00	28000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1079533.00	6295500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	108778830.96	61370678.77
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3063100.00	5695100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1423200.00	1608600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	104292530.96	54066978.77
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	126912402.76	42225316.89
2132	Бусад урсгал шилжүүлэг	3724000.00	3070597.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3724000.00	3070597.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	123188402.76	39154719.89
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	123188402.76	39154719.89
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-91916677.27	28673355.63
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	10187283.35	52184659.04
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	5797700.00	52184659.04
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-10187283.35	-52184659.04
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-102103960.62	-23511303.41

2.3. Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	12,000,000.00	2,838,481.20	406,179,965.87	421,018,447.07
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-2,189,465.79	-2,189,465.79
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	12,000,000.00	2,838,481.20	403,990,500.08	418,828,981.28
C07	Тайлант үеийн үр дүн			-102,103,960.62	-102,103,960.62
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	12,000,000.00	2,838,481.20	301,886,539.46	316,725,020.66
D08	Тайлант үеийн үр дүн			-23,511,303.41	-23,511,303.41
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	12,000,000.00	2,838,481.20	278,375,236.05	293,213,717.25

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	734935700.00	597272600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	734935700.00	597272600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	734935700.00	597272600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	734935700.00	597272600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	734935700.00	597272600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	734935700.00	597272600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	608023297.24	555047283.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	468299574.40	444179623.20
210101	Үндсэн цалин	303207489.02	275632646.38
210102	Нэмэгдэл	74757276.35	103571858.11

210103	Унаа хоолны хөнгөлөлт	50348889.18	58320006.71
210104	Урамшуулал	39985919.85	6655112.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56380840.17	58052864.39
210201	Тэтгэврийн даатгал	33694040.17	40020416.33
210202	Тэтгэмжийн даатгал	5673600.00	4508087.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4540400.00	3606469.43
210204	Ажилгүйдлийн даатгал	1133200.00	901617.55
210205	Эрүүл мэндийн даатгал	11339600.00	9016274.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21465278.67	15912785.28
210301	Гэрэл, цахилгаан	6894718.67	5776622.31
210302	Түлш, халаалт	7714060.00	3606662.97
210303	Цэвэр, бохир ус	709500.00	379500.00
210304	Байрны түрээс	6147000.00	6150000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	37509654.00	17271019.24
210401	Бичиг хэрэг	4634700.00	2930000.00
210402	Тээвэр, шатахуун	23720200.00	9400000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1539869.00	1276019.24
210404	Ном, хэвлэл	484500.00	92000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7130385.00	3573000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11704900.00	6771560.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2267500.00	3746860.00
210604	Урсгал засвар	4537400.00	3024700.00
2107	Томилолт, зочны зардал	4894200.00	1996000.00
210702	Дотоод албан томилолт	4894200.00	1996000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2879550.00	2822031.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	45000.00
210803	Даатгалын үйлчилгээ	420000.00	356700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	443520.00	552031.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	135600.00	111300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1325000.00	1699000.00
210807	Газрын төлбөр	81430.00	28000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	42000.00	30000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4889300.00	8041400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3466100.00	6432800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1423200.00	1608600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	126912402.76	42225316.89
2132	Бусад урсгал шилжүүлэг	3724000.00	3070597.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3724000.00	3070597.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	123188402.76	39154719.89
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	123188402.76	39154719.89

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

	Үзүүлэлт	Тайлант оны
--	----------	-------------

Эдийн засгийн ангилал		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	597272600.00	558117880.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	597272600.00	558117880.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	593972600.00	555047283.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	458765800.00	444179623.20
210101	Үндсэн цалин	282872300.00	275632646.38
210102	Нэмэгдэл	108458700.00	103571858.11
210103	Унаа хоолны хөнгөлөлт	60356000.00	58320006.71
210104	Урамшуулал	7078800.00	6655112.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68008300.00	58052864.39
210201	Тэтгэврийн даатгал	47857800.00	40020416.33
210202	Тэтгэмжийн даатгал	5038100.00	4508087.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4028500.00	3606469.43
210204	Ажилгүйдлийн даатгал	1007700.00	901617.55
210205	Эрүүл мэндийн даатгал	10076200.00	9016274.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21652700.00	15912785.28
210301	Гэрэл, цахилгаан	6906600.00	5776622.31
210302	Түлш, халаалт	4130000.00	3606662.97
210303	Цэвэр, бохир ус	981600.00	379500.00
210304	Байрны түрээс	9634500.00	6150000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17743000.00	17271019.24
210401	Бичиг хэрэг	2930000.00	2930000.00
210402	Тээвэр, шатахуун	9400000.00	9400000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1520000.00	1276019.24
210404	Ном, хэвлэл	320000.00	92000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3573000.00	3573000.00
2105	Нормативт зардал	0.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12075000.00	6771560.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4000000.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5050000.00	3746860.00
210604	Урсгал засвар	3025000.00	3024700.00
2107	Томилолт, зочны зардал	2000000.00	1996000.00
210702	Дотоод албан томилолт	2000000.00	1996000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4677200.00	2822031.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1148900.00	45000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	420000.00	356700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	674000.00	552031.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	111300.00	111300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1725000.00	1699000.00
210807	Газрын төлбөр	28000.00	28000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	70000.00	30000.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9050600.00	8041400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6824500.00	6432800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2226100.00	1608600.00
211	ХҮҮ	0.00	0.00
2111	Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	0.00	0.00
2112	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	0.00	0.00
212	ТАТААС	0.00	0.00
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	0.00	0.00
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	0.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3300000.00	3070597.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3300000.00	3070597.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3300000.00	3070597.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.00	0.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	597272600.00	558117880.11
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	597272600.00	558117880.11
131001	Улсын төсвөөс санхүүжих	597272600.00	558117880.11

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Гадаадын иргэн харьяатын Баруун бүс дэх газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шатахууны зарцуулалтад тавих дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг аудитор Д.Балжинням 2022 оны 01 дүгээр сарын 30-нээс 2022 оны 02 дугаар сарын 06-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 21-ны өдрийн 015/08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

ГИХГББДГазар нь хүний эрх, эрх чөлөө, үндэсний эрх ашгийг дээдэлж, олон улсын жишигт хүрсэн нээлттэй, хариуцлагатай үйл ажиллагааг явуулах гэсэн зорилтыг дэвшүүлэн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Монгол Улсад зорчих түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суух гадаадын иргэнд виз, визийн зөвшөөрөл, оршин суух зөвшөөрөл олгох, хугацааг сунгах хувийн урилга олгох, гадаадын иргэнийг цахим үнэмлэхжүүлэх,
- Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын газарт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх,
- Иргэний харьяалал, цагаачлал, гадаадын гэр бүлд Монгол Улсын харьяат хүүхэд үрчлүүлэх, олон улсын болон гадаадын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газартай холбоотой асуудлыг шийдвэрлэх,
- Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, илэрсэн зөрчлийг шийдвэрлэх,

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Ковид-19 цар тахалтай холбоотойгоо ХЗДХ яамны хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар тус байгууллагад дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Гадаадын иргэн харьяатын Баруун бүс дэх газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгөөр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийн 727,714.5 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 7.2 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 5.8 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Гадаадын иргэн харьяатын Баруун бүс дэх газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 210,303.8 мянган төгрөгөөр буюу 30 хувиар хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 67,610.5 мянган төгрөг болж 1,861.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 725,417.5 мянган төгрөг, оны эцэст 516,975.1 мянган төгрөг болж 208,442.4 мянган төгрөгөөр буурсан нь 153,712.4 мянган төгрөгийн хөрөнгийг акталсан, 58,354.1 мянган төгрөгийн хөрөнгийг систем хооронд шилжүүлсэн, 64,272.6 мянган төгрөгийн хөрөнгийг дахин үнэлгээгээр үнэлэхэд хасалт хийсэнтэй холбоотой байна.

Тайлант онд авлага, өр төлбөр үүсээгүй байна.

Цэвэр хөрөнгө өмчийн дүн дансны оны эхний үлдэгдэл 316,725.0 мянган төгрөг байсан оны эцэст 293,378.7 мянган төгрөг тайлант онд 23,346.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн дансны нөлөөлөл байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Гадаадын иргэн харьяатын Баруун бүс дэх газрын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 725,661.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 725,661.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Хууль зүй дотоод хэргийн яамнаас тус байгууллагын төсвийг 597,272.6 мянган төгрөгөөр батлан ирүүлжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 597,272.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 597,272.6 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 597,272.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 558,117.8 мянган төгрөгийг зарцуулж 39,154.7 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 558,117.8 мянган төгрөг буюу 94 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 24,541.6 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 5,739.9 мянган, хангамж, бараа материалын зардал 471.9 мянган, бага үнэтэй түргэн элэгдэх зардал 5,303.1 мянган, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 3,098.0 мянган төгрөгөөр хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АДОУС 701.8-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АДОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 147 хугацаандаа оруулсан 4 мэдээлэл хугацаа болоогүй, мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэлгүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн орлогын 17, зарлагын 2 гүйлгээ гарсныг тухай бүр шилэн дансны цахим хуудсанд байршуулсан боловч оны эцэст татан төвлөрүүлсэн 1 ажил гүйлгээг мэдээлээгүй байсныг залруулсан.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 зөвлөмж өгөгдсөн бөгөөд 2 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, 1 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй, нийт зөвлөмжийн хэрэгжилт 66 хувьтай хэрэгжсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарал хандуулахуйц асуудал байхгүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 15,889.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 12,089.7 мянган төгрөгийн алдааг залруулж, 1 алдаа зөрчилд 2,000.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1,800.0 мянган төгрөгийн 3 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Тавилга эд хогшил, машин тоног төхөөрөмж дансанд бүртгэлтэй 24 хөрөнгийн тайлант оны элэгдлийн зардлыг тооцоогүй зөрчил илэрлээ.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулан 12,089.7 мянган төгрөгийн залруулга хийж, залруулсан албан тоот ирүүлж санхүүгийн тайланд залруулга хийсэн болно.

4.2 Төлбөрийн акт

1. Тайлант оны батлагдсан төсөвт тээвэр шатахууны зардал 9,400.0 мянган төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 15,800.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулж, гүйцэтгэл 6,400.0 мянган төгрөгөөр хэтэрсэн. Зардал хэтэрсэн шалтгаан нь өмнөх оны санхүүгийн тайланд 8,100.0 мянган төгрөгийн үнийн дүнтэй шатахууны талон худалдан авч нөөцөлсөнтэй холбоотой үүссэн. Тайлант оны эцэст 2,00.0 мянган төгрөгийн үнийн дүн бүхий шатахууны талон худалдан авч нөөц үүсгэсэн нь өмнөх оны санхүүгийн тайлангаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7.7-д “Төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий захирагчийн дансанд татан төвлөрүүлнэ”, 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах гэснийг” мөрдөж ажиллах гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Тайлант онд зарцуулсан шатахууны жолоочийн замын тооцооны хуудасны тооцоог нягтлан бодогч хийж, нийт дүнгээр түлш, шатахууны хэмнэлт, хэтрэлтийг гаргаагүй, шатахууны зарцуулалтад тавих дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, 16.5.4-д “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийг үндэслэн “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар Тооцоог нягтлан бодогч хийж, нийт дүнгээр түлш, шатахууны хэмнэлт, хэтрэлтийг гаргана. гэсэн заалтуудыг мөрдөн ажиллах

2. Засгийн газрын тогтоолын хэрэгжилттэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Тухайн байгууллага нь тайлант онд хот дотор ажил, үйлчилгээнд хөдөлгүүрийн цилиндрийн багтаамж нь 2500 см3-ээс дээш, туулах чадвар өндөртэй, шатахуун их зарцуулдаг авто машинаар 3610 км зам туулахад 722 литр буюу 1.8 сая төгрөгийн зардал гаргаж Засгийн газрын тогтоолыг хэрэгжилтийг ханган ажиллаагүй зөрчил дутагдал илэрлээ.

2.1 Өгсөн зөвлөмж: Монгол улсын Засгийн газрын 2015 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн дугаар 184 тогтоолын 8 дугаар зүйл " Төсвөөс санхүүждэг байгууллага хот дотор ажил, үйлчилгээнд хөдөлгүүрийн цилиндрийн багтаамж нь 2500 см3-ээс дээш, туулах чадвар өндөртэй, шатахуун их зарцуулдаг автомашин хэрэглэх, бүх шатны байгууллага, албан тушаалтан эрхлэх асуудлын хүрээний болон харьяа байгууллагаас автомашин гаргуулан хэрэглэх, шатахууны зардлыг төлүүлэхийг тус тус хориглосугай" гэснийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах.

3. Анхан шатны баримтын бүрдүүлэлт

3.1. Илрүүлэлт: Тайлант онд ажилчдад олгосон цалингийн тооцооны картанд гарын үсэг зуруулж баталгаажуулаагүй зөрчил дутагдал илэрлээ.

3.2.Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.2-д “Аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг мөрдөх анхан шатны баримтын загвар, бүрдүүлэх аргачлалыг санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална”, Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05 өдрийн 347 тоот тушаалын хавсралт ” НХМаягт ЦХ-4” гэсэн заалтуудыг мөрдөн ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Гадаадын иргэн, харьяатын баруун бүс дэх газар	6	15,889.7	2	12,089.7	1	2,000.0	0	0,0	3	1,800.0

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

